



**ДАРХАН-УУЛ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГА**

Бурхантын гудамж-1, 14 дүгээр баг, Дархан сум,
Дархан-Уул аймаг, 45059, Утас: 7037-7121,
Факс: 7037-7121, Цахим шуудан: info@darkhan.gov.mn
Цахим хуудас: www.darkhan.gov.mn

2025.12.19 № 1/795
танай _____-ны № _____ т

СОЁЛЫН ӨВИЙН ҮНДЭСНИЙ ТӨВД

Соёлын биет бус өвийг хамгаалах, сурталчлах, түгээн дэлгэрүүлэх, хөгжүүлэх үйл хэрэгт идэвх санаачилгатай оролцож буй Дархан-Уул аймгийн Дархан сумын 9 дүгээр багийн иргэн, Соёлын биет бус өвийн хоёр дахь үеийн өвлөн уламжлагч Жадамбаагийн Эрхэмсайханыг 2025 оны улсын "ШИЛДЭГ ӨВЛӨН УЛАМЖЛАГЧ"-д нэр дэвшүүлэхээр уламжилж байна.

Холбогдох баримтыг хавсаргав.

Хавсралт...19...хуудастай.

ДАРГА

Б.АЗЖАРГАЛ

4525101317

ZD-2025

**ДАРХАН-УУЛ АЙМГИЙН ДАРХАН СУМЫН
СОЁЛЫН БИЕТ БУС ӨВИЙГ ӨВЛӨН УЛАМЖЛАГЧ
ЖАДАМБААГИЙН ЭРХЭМСАЙХАНЫ ТОВЧ ТАНИЛЦУУЛГА**

2025 оны 12 дугаар сарын 19-ний өдөр

Дархан-Уул аймаг



Дуутан овогт Жадамбаагийн Эрхэмсайхан нь 1964 оны 11 дүгээр сарын 26-нд Дундговь аймгийн Луус суманд төрсөн. Яс үндэс халх. Монгол хэл, уран зохиолын багш мэргэжилтэй. Хэл шинжлэлийн ухааны магистр, Тэргүүлэх зэрэгтэй багш.

Тэрээр боловсролын салбарт 40 орчим жил ажиллахдаа Үндэсний монгол бичгийг сурах, судлах, сурталчлах үйл хэрэгт идэвх зүтгэл гарган өсвөр хойч үе, сурагч багачуудад үндэсний хэл бичиг, утга соёлыг зааж ирсэн бөгөөд сүүлийн 20 гаруй жилд Монголчуудын бичиг, соёлын биет бус өвийг судлах, өвлөн уламжлах чиглэлээр өөрийн оюун ухаан, ур чадвар, авьяас билгээ дайчлан ажиллаж байгаа манай шилдэг өвлөн уламжлагч юм.

1. Үндэсний болон олон улсын хэмжээнд зохион байгуулагдсан уралдаан, тэмцээнд оролцсон байдал

А. Соёл спорт, аялал жуулчлал, залуучуудын яамнаас зохион байгуулсан “НҮҮДЭЛЧИН” дэлхийн соёлын фестиваль наадмуудад 2022, 2023, 2024, 2025 онуудад дараалан амжилттай оролцож, хоёр удаа “ШИЛДЭГ ӨВЛӨН УЛАМЖЛАГЧ”-аар шалгарсан байна.



Зураг:1 “НҮҮДЭЛЧИН” дэлхийн соёлын фестиваль наадмуудад 2022, 2023, 2024, 2025 он


Б. 2022 онд “Эх хэл, аман уламжлал, илэрхийллүүд” төрөлд Үндэсний бичгийг уран зураг, уран баримал, уран хайчилбар, уран дархан зэрэг гар урлалын бусад төрлүүдтэй холбон хийсэн бүтээлүүдээрээ “ШИЛДЭГ ӨВЛӨН УЛАМЖЛАГЧ”





Зураг.2 “НҮҮДЭЛЧИН” дэлхийн соёлын фестиваль наадам 2022 онд

2025 онд “Эх хэл, аман уламжлал, илэрхийллүүд” болон нэн яаралтай хамгаалах өвийн жагсаалтад бүртгэгдсэн “Монголчуудын ном бүтээж ирсэн өв уламжлал” төрөлд уламжлалт нагтан зургийн аргаар бүтээсэн эвхмэл болон хуйлмал судруудаараа “ШИЛДЭГ ӨВЛӨН УЛАМЖЛАГЧ”-аар шалгарсан.



Зураг.3 “НҮҮДЭЛЧИН 2025” дэлхийн соёлын фестиваль наадамд



**Зураг.4 “НҮҮДЭЛЧИН 2025” дэлхийн соёлын фестиваль наадамд
Дархан-Уул аймгаас оролцогчид**

2. Соёлын биет бус өвийг сурталчлах, түгээн дэлгэрүүлэх чиглэлээр дотоод, гадаадад зохион байгуулагдсан арга хэмжээнд идэвхтэй оролцсон байдал.


Соёл спорт, аялал жуулчлал, залуучуудын яамнаас 2024 оны 5 дугаар сард Улаанбаатар хотын Сүхбаатарын талбайд зохион байгуулсан “МОНГОЛ ГЭР” соёл урлагийн үзэсгэлэн арга хэмжээнд оролцож, Монголчуудын хэл бичиг соёлыг өөрийн орны ард иргэд болон гадаадын аялагч жуулчдад сонирхуулж сурталчилсан байна.





Зураг.4 “МОНГОЛ ГЭР” үзэсгэлэн арга хэмжээ-2024

2025 оны 11 дүгээр сарын 19-өөс 12 дугаар сарын 3-нд “ДЭЛХИЙН МӨРӨӨДЛИЙН СУРГУУЛЬ” нийгэмд үйлчлэх төрийн бус байгууллагатай хамтран “НҮҮДЛИЙН СОЁЛЫН БОЛОВСРОЛ” хөтөлбөрийн хүрээнд дэлхийд тархан суурьшсан монголчуудад эх хэл, соёл уламжлалыг таниулан сурталчлах, өвлүүлэн уламжлуулах зорилгоор Франц, ХБНГУ, Бельги зэрэг европын орнуудад зохион байгуулсан үзэсгэлэнд монголчуудын ном судар бүтээж ирсэн өв уламжлалыг шингээн бүтээсэн эвхмэл болон хуйлмал судруудыг дэлгэн сонирхуулж, цаашид энэ чиглэлээр хамтын ажиллагаагаа өргөжүүлэхээр ажиллаж байна.



Зураг.5 Европын улсуудад зохион байгуулсагдсан
“Нүүдлийн соёлын боловсрол”-ын үзэсгэлэнд оролцов

3.Өөрийн санаачилгаар соёлын биет бус өвийг сурталчлах, түгээн дэлгэрүүлэх чиглэлээр дотоод, гадаадад зохион байгуулсан арга хэмжээ:

Тэрээр 2007 оноос хойш төв орон нутгийн боловсрол, соёл, шинжлэх ухааны байгууллагууд болон төрийн бус байгууллагуудтай хамтран ҮНДЭСНИЙ МОНГОЛ БИЧИГ-ийн үзэсгэлэнг тогтмол зохион байгуулж ирсэн байна.

Үүнд: Монгол улсын Үндэсний номын сан (2008), Дархан-Уул аймгийн ЗДТГ (2016), Боловсрол соёлын газар (2015, 2022, 2023), Төв номын сан (2010), Хүүхдийн номын ордон (2007), Музей (2008), ХААИС (2016), “Залуучууд” театр (2016, 2024) “Залуучуудын хөгжлийн төв” (2023) зэрэг газруудад өөрийн бүтээлүүдээр үзэсгэлэн гаргаж, үндэсний бичиг соёлоо түгээжээ.



Зураг.6 “Үндэсний бичиг үсгийн баяр” үзэсгэлэн



Зураг.7 “Зохиолч уншигчдын уулзалт” 2015 онд



Зураг.8 “Үндэсний бичиг соёлын үзэсгэлэн” Боловсрол соёлын газар 2022 онд



**“ДЭЛХИЙН НОМЫН ӨДӨР”, “ҮНДЭСНИЙ БИЧИГ ҮСГИЙН БАЯРЫН ӨДӨР”-ИЙГ ТОХИОЛДУУЛАН ДАРХАНЫ СОЁЛЫН БАЙГУУЛЛАГУУДААС
ЗОХИОН БАЙГУУЛАХ АЖЛЫН ХӨТӨЛБӨР**



Төрт ба Хаалмын сан"-гийн тэргүүн,
профессор, зохиолч, орчуулагч,
Дугтарсүрэнгийн Гүн-Үйлэс



МУСТЗ зохиолч,
сэтгүүлч
Дамжавын Жамьян



Зохиолч, сэтгүүлч,
Баатарсүрэнгийн
Шүлэригэнэ



Зохиолч, орчуулагч
Дашин Оюунчимэг



АБТА, Хэл шинжлэлийн
ухамны магистр
Жаламбаатын Эрхэмсайхан



Түүхч, нийтлэгч,
зохиолч, сэтгүүлч
Балсаннорын Номинчимэг



МЭЗ-ийн гишүүн, зохиолч
Самжаагийн Батжаргал



Зохиолч, сэтгүүлч
Балсаннорын
Ойдов

ХӨТӨЛБӨР

2016.05.07-ны өдөр Залуучууд театрын 1-р давхарын фойенд

- 11⁰⁰-16⁰⁰ Зохиолчдын гарын үсэгтэй, 30-50%-ийн хямдралтай номын худалдаа,
уран бүтээлчдийн болон “Бидний монгол бичиг” сэдэвчилсэн номын үзэсгэлэн
14⁰⁰-15³⁰ “Зохиолч уншигчдын уулзалт”
15³⁰-16⁰⁰ Хаалтын ажиллагаа

Дээрх арга хэмжээний хүрээнд ЕБС-ийн багш сурагчид, 30-р сургуулийн сургалтын
менежер Ж.Эрхэмсайхан нарын “Гайхамшигт Монгол бичиг” Үндэсний бичгийн
бүтээлүүдийн үзэсгэлэн

2016.05.05-ны өдөр Хүүхдийн номын ордны 202 тоот өрөөнд

- 15⁰⁰-16⁰⁰ ЕБС-ийн 8-9-р ангийн сурагчдын дунд Үндэсний бичгийн хурдан уншлага,
уран бичлэгийн уралдаан

ЗОХИОН БАЙГУУЛАГЧИД



БОЛОВСРОЛ
СОЁЛЫН ГАЗАР



ТӨВ
НОМЫН САН



ХҮҮХДИЙН
НОМЫН ОРДОН



АЙМГИЙН
МУЗЕЙ



ЗАЛУУЧУУД
ТЕАТР




ЗОХИОЛЧДЫН
“ХЯЗГААРГҮЙ
ОРЧЛОН” ТӨВ



“НОМЫН ҮНДЭМЭ”
НОМЫН
ДЭЛГҮҮР

**Номын худалдаа
30-50%
хямдралтай**

Зураг.9 “Дэлхийн яруу найргийн өдөр - Үндэсний бичиг үсгийн баяр”
Залуучууд” театрт 2016 онд



Зураг.10 “Зочинтой өдөр” Төв номын сан 2024 онд

Улс тунхагласны баярын өдрөөр аймгийн Засаг даргын тамгын газрын байранд “Бид Монголоороо бахархдаг” үзэсгэлэнг зохион байгуулсан.




Зураг.11 2016 оны 11 сарын 25 Аймгийн ЗДТГазарт

“ХҮМҮҮН БИЧИГ” сониноос жил бүр уламжлал болгон зохион байгуулдаг “МОНГОЛЫН САЙХАН БИЧИГТЭН” улсын уралдаанд удаа дараа оролцож байсан. Мөн Дархан-Уул аймгийн Засаг даргын тамгын газраас жил бүрийн зуны тэргүүн сард зохион байгуулдаг ДАРХАН ХАЙРХАН УУЛ-ын тахилгын айлтгал бичгийг үйлджээ.



Зураг.12 “ХҮМҮҮН БИЧИГ”, “МОНГОЛЫН САЙХАН БИЧИГТЭН” улсын уралдаан



Зураг.13 Дархан хотын 62 жилийн ойгоор “Үндэсний бичиг соёлын үзэсгэлэн 2023 онд



**Зураг.14 2024 онд зохион байгуулагдсан “Нүүдэлчин” дэлхийн соёлын фестивалд оролцсон
Соёлын биет бус өвийг өвлөн уламжлагчдын хамт**

Аймгийн Музейтэй хамтран нийт ажилтнуудад зориулан “Төр нийгмийн зүтгэлтнүүдийн гар бичмэл” сэдвээр сургалт, ШУТИС-ийн оюутнуудын дунд “Марзан Шаравын зураг ба Гэрийн ерөөл” сэдэвт лекц зэргийг амжилттай зохион байгуулсан нь тэдэнд монгол ахуй соёл, өв уламжлал, эд хэрэглэлтэй биечлэн танилцах өргөн боломж олгож, ардын аман зохиол ерөөл магтаал нь сонгодог уран зурагт хэрхэн туссан байгааг бодитойгоор харуулсан сонирхолтой ажил болжээ.



Зураг.15 “Марзан Шаравын зураг ба Гэрийн ерөөл” сэдэвт үзэсгэлэн



Зураг.16 “Үндэсний бичиг соёлын баяр”-ын үзэсгэлэн 2022 онд



3.Соёлын биет бус өвийг хамгаалах, хөгжүүлэх үйл хэрэгт идэвх, санаачилгатай оролцсон байдал

Монгол бичгийн сургалтын үр өгөөжийг дээшлүүлэх, сурагчдад сонирхолтой болгох, тэдний мэдлэгийн хүрээг тэлж, уран зураг, уран барилга, уран баримал зэрэг урлагийн бусад төрлүүдтэй холбон заах боломжийн талаар сургалтын үзүүлэн таниулах материалыг бэлтгэж, багш нарт сургалт зохион байгуулсан байна. Энд дүрс багтаан бичих, дүрсэд багтаах бичих, угалзлан эвхэж бичих, дөрвөлжлөн эвхэж бичих зэрэг төрөл бүрийн бүтээлч арга барилыг ашиглан уг бичиж буй зүйлийнхээ агуулгыг илүү тодорхой болгох, мөн эхлэн суралцаж буй хүмүүсийн сонирхлыг татаж, үндэсний бичгээ улам гүнзгийрүүлэн судлах сэдэл тэмүүлэл төрүүлэхээр зорин ажиллаж байна.



Зураг.17 Монгол бичгийн бүтээлүүдийг 2010 онд Аймгийн Музейн үзмэр баяжилтыг нэмэгдүүлэв

Төрийн албанд үндэсний бичгийн хэрэглэж эхлэхтэй холбогдуулан “Төр нийгмийн зүтгэлтнүүдийн гар бичмэл” гарын авлагыг бэлтгэн хэвлүүлж, иргэд хөдөлмөрчдийн унших бичих чадварыг сайжруулах, уламжлалт албан бичгийн хэл найруулгаас бүтээлчээр суралцах боломжийг бүрдүүлэн аймгийн Музей, Төв номын сан, Байгал орчны газар, Шүүх прокурорын ажилтнуудад сургалт зохион байгуулсан.



Зураг.18 “Төр нийгмийн зүтгэлтнүүдийн гар бичмэл” гарын авлага

Энэхүү гарын авлагад Д.Бодоо, Б.Цэрэндорж, А.Амар, Х.Чойбалсан зэрэг үе үеийн ерөнхий сайдууд, Цэргийн яамны сайд Д.Сүхбаатар, Да лам Г.Цэрэнчимэд, Дилав хутагт Б.Жамсранжав, их зохиолч Д.Нацагдорж, С.Буяннэмэх, Ц.Дамдинсүрэн, Б.Ринчен, эрдэмтэн Онход овогт С.Жамьян, Ж.Цэвээн, харчин гүн Б.Хайсан, финландын хэл шинжлэлийн эрдэмтэн Рамстедт зэрэг 20 хүний гар бичмэлийг багтаасны зэрэгцээ уламжлалт албан бичгийн төрөл болох айлтгах бичиг, өргөх бичиг, илгээх бичиг, тушаах бичгийн найруулгын онцлог, гол ялгаа зэргийг бодитой жишээн дээр үзүүлж, уламжлалт найруулгын мөр дарах болон мөр тэтгэх ёсыг тодорхой жишээн дээр тайлбарласан байна.


1648 онд Ойрадын Зая бандид Намхайжанцангийн зохиосон тод бичгийг бие даан сурч, зарим бүтээлээ үндэсний монгол бичиг болон тод бичгээр харьцуулан бичсэн нь сонирхолтой болсон. Жишээ нь: Ж.Бадраагийн “ХАЛУУН ЭЛГЭН НУТАГ” дууны үгийг монгол бичиг болон тод үсгээр арьсан дээр бичсэн байгаа нь энэ хоёр бичгийн онцлог ялгааг тодорхой харуулаад зогсохгүй цаашид гүнзгийрүүлэн судлах суралцах боломжийг нээж өгч байна.



Зураг.19 Монгол бичиг болон тод бичгээр харьцуулан бичсэн

“ХАЛУУН ЭЛГЭН НУТАГ” дууны шүлэг

“Монгол ардын 30 дуу”, “Өвөр монгол ардын 44 дуу” зэргийг уламжлалт нагтан зургийн аргаар хуйлмал ном хэлбэрээр бүтээсэн нь үзэгчдийн сонирхлыг татсан төдийгүй мэргэжлийн дуучидтай хамтран мартагдсан хуучин дуунуудыг сэргээн өвлүүлэх, уран бүтээлчдийн урын санг баяжуулах ажлыг ЭХЛҮҮЛЖ Залуучууд театрын уран бүтээлчдэд танилцуулав.



Зураг. 20 “Гавалмаа”, “Талд унасан жавар” “Сийрэнбуу” дууны үг

Хуучин бичгийн мэргэд, албаны хүмүүс хувийн тамга, дардас хэрэглэдэг байсан соёл уламжлалыг сэргээх зорилгоор багш нар, уран бүтээлчид, зохиолч яруу найрагч, сэтгүүлч сурвалжлагч, шүүгч, уран бичээч зэрэг 40 орчим хүнд хувийн тамга, дардсыг захиалгаар хийж өгсөн байна. Мөн "Бичгийн гэрийн дөрвөн эрдэнэ" болох бийр, бэх, муутуу, янтай зэргийг дэлгэн үзүүлж, тус бүрийн үүрэг зориулалт, хэрхэн хэрэглэх зэргийг тайлбарлан таниулжээ.



Зураг.21 Бичгийн хэрэгсэл, хувийн тамга дардас



Зураг.22 Үндэсний бичгээр хэвлэгдсэн ховор хуучин номнуудын үзэсгэлэн



8-2012

and I will be happy to see you

[illegible]

[Handwritten signature]

مستطابك راجد

٢٠١٥ م . ٩ شعبان . بطن

٣٧٨٤

٦٠٠



No. 02

Хүндэт нөхөр

М. Эрхисайхан таны
Дархан-Уул аймгийн эдийн засаг,
нийгмийн, соёлын хөгжилд
оруулсан зүтгэл бүтээлийг үнэлж
"НАЙРАМДЛЫН ДАРХАН"
тэмдгээр шагнав.

Засаг дарга

200.8 он 0.8 сар 29 өдөр



ОЮУН УХААН бол тэнгэр
газар хоёрын хаан нь юм.
СОКРАТ

ЖАДАМБАА ОВОГТОЙ

ЭРХЭМ САЙХАН

ОЮУН УХААНЫГ ДЭЭДЛЭГЧ

лиар шагнаж 05 дугаар

ний энэхүү үнэмлэхийг олгов.

ОЮУНЫ ЧАДВАРЫН
IQ ТӨС

Монгол Улсын Оюуны Чадварын IQ
төвийн тэргүүн

[Handwritten signature]

2008 оны 04 сарын 29 өдөр
Улаанбаатар хот

Дугаар 05

ОЮУН УХААН бол тэнгэр
газар хоёрын хаан нь юм.
СОКРАТ



Дугаар 05

ЖАДАМБАА ОБЪЕКТОЙ

ЭРХЭМ САЙХАН -г

ОЮУН УХААНЫГ ДЭЭДЛЭГЧ

медалиар шагнаж 05 дугаар

бүхий энэхүү үнэмлэхийг олгов.

**ОЮУНЫ ЧАДВАРЫН
IQ ТӨС**

Монгол Улсын Оюуны Чадварын IQ
төвийн тэргүүн

Handwritten signature

Ц.ДЭМБЭРЭЛ

2008 оны 04 сарын 29 өдөр
Улаанбаатар хот



КМТН

8-2012-019

МОНГОЛЫН ОЮУНЫ ЧАДВАРЫН ТӨВ

МОНГОЛЫН ОЮУНЫ ЧАДВАРЫН ТӨВ
МОНГОЛЫН ОЮУНЫ ЧАДВАРЫН ТӨВ
МОНГОЛЫН ОЮУНЫ ЧАДВАРЫН ТӨВ

МОНГОЛЫН ОЮУНЫ ЧАДВАРЫН ТӨВ
МОНГОЛЫН ОЮУНЫ ЧАДВАРЫН ТӨВ
МОНГОЛЫН ОЮУНЫ ЧАДВАРЫН ТӨВ

1. *Handwritten text, likely a signature or name, written vertically.*

[illegible][illegible]

ਮੇਰਾ ਪਿਆਰ ਹੋਵੇ

№ 02

Хүндэт нөхөр

...М. Эрхисайхан... таны
Дархан-Уул аймгийн эдийн засаг,
нийгмийн, соёлын хөгжилд
оруулсан зүтгэл бүтээлийг үнэлж
“НАЙРАМДЛЫН ДАРХАН”
тэмдгээр шагнав.

Засаг дарга...

2008 он 08 сар 29 өдөр



**ДАРХАН-УУЛ АЙМГИЙН ДАРХАН СУМЫН СОЁЛЫН БИЕТ БУС ӨВИЙГ ӨВЛӨН УЛАМЖЛАГЧ
ЖАДАМБААГИЙН ЭРХЭМСАЙХАНЫ БҮТЭЭЛҮҮДИЙН ТАЛААР ЦАХИМ ОРЧИН НИЙТЭЛСЭН
МЭДЭЭЛЭЛ, НЭВТРҮҮЛГҮҮД**

№	Агуулга	Он	Эх сурвалж	Цахим холбоос
1	“Хөнгөн бийрийг хөшихийн учир”	2011	ЛХА тв	https://www.facebook.com/reel/1920376448785
2	Номын ертөнц “Элит номын сан”	2015	UBS тв	https://www.youtube.com/watch?v=jXs7YTUGcus
3	“Ярилцах цаг”	2016	DBS тв	https://www.youtube.com/watch?v=74cxJR1PkQE
4	Хуйлмал ба эвхмэл судрууд	2024	Цэц.мн	https://www.facebook.com/reel/434923295559057
5	“Номд дурлагсад”	2024	Төв номын сан	https://www.facebook.com/reel/4205859429640372
6	Цагаан сарын нэвтрүүлэг	2025	Аймгийн ЗДТГ	https://www.facebook.com/reel/4123539224594726

ШАГНАЛ УРАМШУУЛАЛ

№	Шагналын нэр	Шагнал авсан он
1	Боловсролын Тэргүүний Ажилтан 2006	2000 он
2	Аймгийн Засаг Даргын Жуух бичиг 2000	2000 он
3	БШУЯ-ны Жуух бичиг	2001 он
4	“Найрамдлын Дархан” тэмдэг 2008	2004 он
5	Аймгийн “Тэргүүний ажилтан” 2004	2004 он
6	“Үндэсний бичиг соёлыг дэлгэрүүлэгч” 2012	2012 он
7	“Шилдэг өвлөн уламжлагч” 2022	2022 он
8	“Шилдэг өвлөн уламжлагч” 2025	2025 он

ТОДОРХОЙЛОЛТ ГАРГАСАН:

**ДАРХАН-УУЛ АЙМГИЙН СОЁЛ, УРЛАГ, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛ,
ЗАЛУУЧУУДЫН ГАЗРЫН ДАРГА** **Х.СОЁЛ-ЭРДЭНЭ**

